




**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЦОГТ СУМЫН МАН-ЫН
ХОРООНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР
/2020-2024 ОН/**

**АЛТАЙ ХОТ
2020 ОН**



ДНОА0060 9018301

Говь-Алтай Цогт сумын МАН-ын хорооны

2020 оны 06 сарын 13-ны өдрийн

13 дугаар тогтоолын хавсралт



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2021-2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ - НИЙГМИЙН БОДЛОГО

1. Эрүүл мэндийн чиглэлээр
2. Биеийн тамир, спортын чиглэлээр
3. Боловсрол, соёл, шинжлэх ухааны хөгжлийг дэмжих чиглэлээр
4. Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр
5. Хүүхэд, залуучууд, ахмад, эмэгтэйчүүдийг дэмжих чиглэлээр

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО

1. Мал аж ахуйг эрчимжүүлэх чиглэлээр
2. Газар тариалан эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр
3. Бизнес эрхлэлтийг дэмжих чиглэлээр
4. Төсөл, зээлийн таатай орчныг бий болгох чиглэлээр
5. Ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр

ГУРАВ. ДЭД БҮТЦИЙН БОДЛОГО

1. Зам, тээвэр, үйлдвэржилтийн бүтээн байгуулалтын чиглэлээр
2. Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилийн чиглэлээр
3. Ариутгах татуурга, ундны усны найдвартай эх үүсвэрийн чиглэлээр
4. Эрчим хүчний өргөтгөл, шинэчлэлийн чиглэлээр
5. Хот байгуулалт, барилга орон сууцны хөгжлийн чиглэлээр

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН – АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО

1. Онгон байгалиа хамгаалах чиглэлээр
2. Орон нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлэх
3. Бичил уурхай иргэдийн оролцоо
4. Улс болон орон нутгийн тусгай хамгаалалтыг нэмэгдүүлнэ
5. Цөлжилт, элсний нүүдлээс хамгаалах, ногоон байгууламж

ТАВ. ИРГЭДИЙН ОРОЛЦОО - ЗӨВ ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

1. Эрх мэдэлтнийг биш, эрх зүйт төрийг дээдэлнэ.
2. Түмэндээ ойртсон төрийн үйлчилгээ
3. Авилга, хүнд суртал, чирэгдэлгүй зөв засаглал
4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах



НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ – НИЙГМИЙН БОДЛОГО

Мэргэжлийн чадварлаг боловсон хүчнээр бүрэн хангагдсан, эрүүл мэнд, боловсрол, соёл, халамжийн үйлчилгээг чанаржуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээнийг өргөн хүрээтэй болгож хүртээмж, үр өгөөжийг нэмэгдүүлэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар иргэн бүрийн амьдарлын чанарыг дээшлүүлнэ.

1.1. Эрүүл мэндийн чиглэлээр

1.1.1. Орон нутгийн эмч, эмнэлгийн ажилтнуудын хүрэлцээ хангамж ур чадварыг сайжруулан, эмчилгээ оношилгооны дэвшилтэт технологи арга барилыг эзэмшүүлж, нэвтрүүлэх асуудлуудыг үе шаттай шийдвэрлэнэ.

1.1.2. Сумын иргэдийг эрүүл мэндийн бүрэн оношилгоонд жил бүр хамруулах ажлыг зохион байгуулна.

1.1.3. Эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг урт, богино хугацааны сургалтанд хамруулж, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулна.

1.1.4. Эрүүл мэндийн талаар хэрэгжүүлж байгаа аймгийн дэд хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлж, эрүүл зан үйлийг хэвшүүлэх, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн сургалт сурталчилгааг тогтмолжуулна.

1.1.5. Эх, хүүхдийн эндэгдлийг гаргахгүй байх нөхцлийг бүрдүүлнэ.

1.1.6. Сумын хэмжээнд стандартын шаардлага хангасан эмийн сангийн хүртээмжийг нэмэгдүүлж, малчдад эм, эмнэлгийн үйлчилгээг ойртуулж ажиллана.

1.1.7. Эмч, эмнэлгийн ажиллагсдын нийгмийн баталгааг хангаж, боловсон хүчнийг бэлтгэж чадваржуулна.


1.1.8. Мэдээллийн технологийн ололтыг эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашиглан Мобайль технологийг ашиглана.

1.1.9. Эрүүл мэндийн явуулын амбулатор, үзлэг, оношилгоог бүх багт жил бүр зохион байгуулж малчдад нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлнэ.

1.1.10. Ахмадуудад эмнэлгийн үзлэг оношилгоо хийж, эмчилгээ сувилгаанд тогтмол хамруулж ахмадуудад ээлтэй Эрүүл мэндийн төв болгоно.

1.1.11. Хөгжлийн бэрхшээлтэй болон эмзэг бүлгийн иргэдийг эрүүл мэндийн үзлэг оношилгоо, урьдчилан сэргийлэх эмчилгээ, сувилгаанд тогтмол хамруулна.

1.1.12. Орон нутгийн онцлогт тулгуурлан эмчилгээ, сувилал, амралтын газар байгуулах хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж, уламжлалт эмнэлгийн үйлчилгээг хөгжүүлнэ.



1.1.13..Хүчилтөрөгчийн болон зүрхний цахилгаан бичлэг, ЭХО аппараттай, мобайл технологийн ашиглалтыг сайжруулж бусад шаардлагатай техник хэрэгслээр хангах асуудлыг эрүүл мэндийн газар болон аймаг, хот дахь нутгийн зөвлөлтэй хамтран шийдвэрлэнэ.

1.1.14. Багийн эмч нарын унаажуулах асуудлыг 2 жилд 1 удаа шинэчлэж байхаар шийдвэрлэнэ (мотоцикль)

1.1.16. Хүн эмнэлгийг түшиглүүлэн Гэр сувилал ажиллуулна

1.2.Биеийн тамир, спортын чиглэлээр

1.2.1. Нийтийн биеийн тамирыг бүх нийтийн хүртээл болгон хүн амыг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, ажлыг эрчимжүүлж, чийрэгжүүлэх танхимыг сумын төв, байгууллагуудад зохистой хэлбэрээр бий болгон хөгжүүлж, хүн амын дундаж наслалтыг улсын дундаж түвшинд хүргэх нөхцлийг бүрдүүлнэ.

1.2.2. Орон нутагт хөгжүүлэх боломжтой зарим нэр төрлийн спортыг бодлогын хэмжээнд дэмжиж аймаг, улс бүсийн аваргыг сум орон нутгаас төрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1.2.3. Хүүхэд залуучуудыг үндэсний спортоор хичээллэх нөхцлийг бүрдүүлэн, амжилт гаргасан тамирчдыг дэмжиж, үндэсний спортын холбоодтой хамтран ажиллана.

1.2.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх, уралдаан тэмцээнд оролцох нөхцлөөр хангана.

1.2.5. Хүүхэд залуучуудыг биеийн тамир, спортоор хичээллэх боломж нөхцлийг бүрдүүлж, спорт заалыг шинээр барих, тоног төхөөрөмж, хувцас хэрэглэгдэхүүнээр хангаж шинэчлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.


1.2.6. Шатар, теннисний спортын менежментийг сайжруулан өрх бүр хүүхдийн шатар тоглох орчинг бүрдүүлэн шатартай болох аян зохион байгуулна.

1.2.7. Сумын хэмжээний биеийн тамирын спорт заалтай болж, биеийн тамир спортын хэрэглэгдэхүүн тоног төхөөрөмж хувцас хэрэгслээр хангах шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.3. Боловсрол, соёл, шинжлэх ухааны хөгжлийг дэмжих чиглэлээр

1.3.1. Боловсрол, соёлын салбарыг чадварлаг боловсон хүчнээр тасралтгүй хангагдах боломжийг бий болгож, удирдах ажилтны ур чадвар, арга барилыг дээшлүүлэх, өндөр мэргэшилтэй багш, соёлын ажилтнуудыг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах таатай орчныг бүрдүүлнэ.

1.3.2. Бүх нийтийн боловсролын түвшинг дээшлүүлэн, хичээлийн байр болон цэцэрлэгийн орчин нөхцлийг сайжруулж, сургалтын материаллаг бааз, тоног



төхөөрөмжөөр хангагдсан, орчин үеийн дэвшилтэт технологи бүхий сургалтын орчинг бүрдүүлнэ.

1.3.3. Математик, англи хэл, компьютерийн болон бусад хичээлүүдийн сургалтын түвшинг нарийвчлан тогтоож, цаашид сайжруулах тусгай хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

1.3.4. Улс аймгийн төрөлжсөн олимпиад, багшийн ур чадварын болон илтгэлийн уралдаануудад амжилттай оролцсон багш сурагчдын оюуны үнэлэмжийг урамшуулдаг системд шилжинэ.

1.3.5. Цэцэрлэгийг цэвэр бохир усны системтэй болгоно.

1.3.6. Нүүдлийн гэр цэцэрлэг, хүүхдийн зусланг тогтмол ажиллуулна.

1.3.7. Насан туршийн боловсролын хүртээмж, чанар, үр өгөөжийг дээшлүүлнэ.

1.3.8. Шинэ залуу багш нарыг хөгжүүлэхэд анхааран багш хөгжлийн төвийнажлыг чанаржуулж, багш нарыг мэргэшүүлэх сургалтанд хамруулж чадавхижуулна.

1.3.9. “Алтайн алтан өв” өв соёл, хүүхдийн урлагийн их наадам бусад уралдаан тэмцээнд тогтмол оролцуулж, хүүхэд залуучуудын чөлөөт цагийн танхим бий болгож, хүүхэд залуучуудын чөлөөт цагаараа сурч боловсрох, хөгжих орчинг бий болгоно.

1.3.10. Сургуулийн дотуур байрны тохижилтыг хийж малчдын хүүхдийн сурч, боловсрох, хөгжих орчныг сайжруулна.

1.3.11. Соёлын төвийг орчин үеийн тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг, хувцас хэрэглэлээр хангах ажлыг дэмжин, багуудад урлагийн үйлчилгээг жилд 1-2 удаа хүргэж, номын сангийн фондыг баяжуулан, шинэчлэх ажлыг нэн тэргүүнд зохион байгуулах.


1.3.12. Сумын соёлын биет болон биет бус өвийг хадгалах, өвлүүлэх олны хүртээл болгох чиглэлээр хийгдсэн ажлуудыг бататгаж, бүртгэлжүүлэх, томоохон хэмжээний зан заншил соёлын өв тээгчдийг илрүүлэн урамшуулж баталгаажуулна.

1.3.13. Түүх соёл, ёс заншил уламжлалаа дээдлэх үндэсний үзлийг түгээн дэлгэрүүлж өрх бүрийг ургийн бичиг хөтлөх зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.4.14. Соёлын төвийн ажилтан, мэргэжилтнүүдийн мэргэшүүлэх сургалтанд хамруулж чадавхижуулна.

1.4. Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр

1.4.1. Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэг, эмзэг бүлгийн иргэдэд хүргэж, нийгмийн даатгалд хамрагдах хүрээг нэмэгдүүлнэ.



1.4.2. Эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй уялдуулан ажлын байрыг тууштай нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг багасган, өрхийн амьжиргааг дээшлүүлнэ.

1.4.3. Ажлын байр шинээр бий болгож буй аж ахуйн нэгж, байгууллагыг бүх түвшинд орон нутгийн бодлогоор дэмжинэ.

1.4.4. Байгаль орчныг хамгаалах, бүтээн байгуулалт, нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжийн тохижилт үйлчилгээний ажилд амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийг өргөнөөр татан оролцуулах замаар өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.

1.4.5. Малчдын нийгмийн хамгааллын талаар шинэ санаачлага гаргаж, залуу малчдыг бүх талаар дэмжинэ.

1.5. Хүүхэд, залуучууд, ахмад, эмэгтэйчүүдийг дэмжих чиглэлээр

1.5.1. Хүүхэд залуучуудын хэрэгцээ шаардлагад суурилсан, сурч боловсрох, хөгжих, соёл хүмүүжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн аймгийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

1.5.2. Ахмад настан, эмэгтэйчүүдийн хэрэгцээ чадамжинд суурилсан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх байнгын орлоготой байх нөхцлийг бүрдүүлнэ.


1.5.3. Хүүхэд залуучууд, ахмадууд, эмэгтэйчүүдийн холбоод, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж тэдгээрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сурч боловсрох, хөгжиж дэвжих, соёл хүмүүжил, уламжлал ёс заншлаа өвлүүлэх, ажил хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажиллана.

1.5.4. Нийгмийн хамгааллын хуульд заасны дагуу төсөвт байгууллагуудын төсвийн хэмнэлтээс ахмадуудад зориулсан сан бүрдүүлэх, амарч сувилуулах, ахмад настныг хөдөлгөөний дутагдлаас хамгаалах чийрэгжүүлэх зэрэг нийгмийн хамгааллын арга хэмжээг үргэжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.5.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санг дэмжсэн иргэд, хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжиж сангийн хөрөнгийг зарцуулах журмын дагуу үйл ажиллагаа үргэжлүүлэн явуулна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО

Эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, хөгжилд чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлэн үр ашгийг нь дээшлүүлж, ажлын байр бий болгон ард иргэдийн өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.



2.1 Мал аж ахуйг эрчимжүүлэх чиглэлээр

2.1.1 Мал сүргийн эрүүл мэндийн талаар цогц үйлчилгээг үзүүлэхэд мэргэжлийн байгууллагын эмч мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж дэмжлэг үзүүлнэ.

2.1.2. Орон нутгийн эдийн засгийг тэлэх бодлогыг баримталж, байгууллага аж ахуйн нэгжийн санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, айл өрх, иргэд, худалдаа эрхлэгчдийн орлогыг өсгөхөд шаардагдах орон нутгийн шийдвэрүүдийг богино хугацаанд гаргаж ажиллана.

2.1.3 Малжуулах аянг үргэлжлүүлэн, мал аж ахуйн үйлдвэрлэлд тогтвортой ажиллаж байгаа цөөн малтай малчин өрх, залуу малчдыг эхний ээлжинд хамруулах арга хэмжээг авна.

2.1.4. Мах, сүүний үхэр, сүүний ямаа, махны хонь зэрэг өндөр ашиг шимтэй малын фермерийн аж ахуйг хөгжүүлэх сонирхлыг дэмжиж ажиллана.

2.1.5. Сумын өвс тэжээлийн нөөцийн цэгийг бий болгож, аюулгүйн нөөцийн санг бүрдүүлэн мал аж ахуйг эрсдлээс хамгаалах арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулна.

2.1.6. Бэлчээрийг улирлын хуваарийн дагуу ашиглах гэрээ байгуулж, өнжөөж сэргээх, хашиж хамгаалах зэрэг арга хэмжээг тууштай хэрэгжүүлж, хортон мэрэгчтэй тэмцэх ашигтай аргыг нэвтрүүлж, үр дүнг дээшлүүлнэ.

2.1.7. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдийн хоршоодын үйл ажиллагааг эрчимжүүлэн дэмжиж, биржийн арилжаанд оролцох эрхтэй иргэд, аж ахуйн нэгжүүдийг бий болгоно.


2.1.8. Таван хошуу малын хээлтүүлэгчийг чанаржуулж, сүргийн бүтцийг хадгалж үр ашгийг нэмэгдүүлэх замаар мах сүү, ноолуурын чанар гарцыг дээшлүүлж эдийн засгийн үр өгөөжийг дээлүүлэхийн тулд Цогт сумын Есөн-Улаан булаг ХХК-ны үйлчилгээний ажил үйлчилгээг сайжруулж Нутгийн шилмэл омгийн цөм сүргийг бий болгох үйлдэр болгон баталгаажуулахад дэмжлэг үзүүлэх.

2.1.9. Малчдаа дэмжих орон нутгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, ахмад үеийн малчид болон улс аймаг, сумын сайн малчдын арга туршлага, мал маллах арга ухааныг залуу малчдад эзэмшүүлэх ажлыг зохион байгуулж ажиллана.

2.1.10. Багуудад загвар өвөлжөө, хаваржаа бий болгоно.

2.1.11. Хуучин хашаа хороог сэргээн засварлах, шинээр хашаа барих ажлыг эхлүүлнэ.

2.2. Газар тариалан эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр



2.2.1 Азын хөгжлийн банкны дэмжлэгээр Хаягийн услалтын услалтын системийг ашиглалтанд оруулахад нь хамтран ажиллаж цаашид үрийн аж ахуй байгуулагдах ажилд хамтран оролцох

2.2.2. Жимс жимсгэнэ, чацарганы тариалалтыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

2.2.3. Төмс хүнсний ногоо хадгалах зоорийг, байнгын ашиглалттай болгон, сумын иргэдийг өөрсдийн тариалсан хүнсний ногоогоор хангах бодлогыг хэрэгжүүлнэ.

2.2.4. Хүлэмжийн аж ахуй хөгжүүлэх, гэрэл цахилгааны асуудлыг шийдвэрлэн ялангуяа өвлийн дулаалгатай хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлнэ.

2.3 Бизнес эрхлэлтийг дэмжих чиглэлээр

2.3.1 Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа дэмжин эдийн засгийн таатай орчинг бүрдүүлж, төрийн байгууллагын хууль бус дарамт шахалтыг арилгана.

2.3.2. Жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг төсөл хөтөлбөрүүдэд хамруулж, ажлын үр өгөөж хүртээмжийг дээшлүүлнэ.

2.3.3. Гарааны бизнес эрхлэгчдэд аж ахуй эрхлэх сургалтуудыг зохион байгуулж, тэднийг шаардлагатай мэдээ мэдээллээр хангах, техник технологийн сонголт хийхэд нь туслах, төсөл боловсруулах явцад нь зөвлөгөө өгч аймгийн инкубацийн үйлчилгээнд хамруулж үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

2.3.4. Баялаг бүтээгчид болон өрхийн үйлдвэрлэгчдийг дэмжин иргэд худалдан авагчдын эрэлт хэрэгцээг хангасан "Цогт-Түншлэл" үзэсгэлэн худалдааг жил бүр орон нутагтаа зохион явуулж үндэсний шилдэг үйлдвэрлэгчдийг тодруулан урамшуулж, шилдгүүдийг "Алтай түншлэл" аймгийн үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж дэмжиж ажиллана.


2.3.5. Сумын хэмжээнд 2-оос доошгүй брэнд бүтээгдэхүүнийг патентжуулахад дэмжиж ажиллана.

2.4. Төсөл зээлийн таатай орчинг бий болгох чиглэлээр

2.4.1 Зээл, төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн мэдээллийн санг байгуулж, төсөл хөтөлбөрт өрх бүрийг ялгаварлан гадуурахгүйгээр жигд хамрагдах боломжийг бүрдүүлнэ.

2.4.2. Орон нутагт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдэд тавих хяналтыг нэмэгдүүлж, хэрэгжилтийг ханган иргэдэд төсөл хөтөлбөрийн талаарх мэдээллийг нээлттэй ил тод хүргэнэ.

2.4.3. Олон улсын болон орон нутгийн төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулна.




2.5. Ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр

- 2.5.1. Үйлдвэрлэл худалдаа эрхлэгчдийн ажиллах орчин нөхцлийг сайжруулж, орон нутагт ажлын байр шинээр бий болгох ажил үйлчилгээг бодлогоор дэмжинэ.
- 2.5.2. Нөхөрлөл хоршоо, аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллах замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 2.5.3. Орон нутагт хэрэгжих томоохон төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж хамтран ажиллах замаар шинэ ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 2.5.4 Ажилгүй, амжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд мэргэжил олгох сургалтанд хамруулж, бүлэг, нөхөрлөл, хоршоонд хамруулан ажлын байртай болоход нь дэмжлэг үзүүлж ажиллана.
- 2.5.5 Хоршоо болон жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж, багуудын хөгжлийн хөтөлбөрүүдийг дэмжиж ажиллана.
- 2.5.6. Нийтийн ахуйн үйлчилгээний төвийг шинээр байгуулж үйл ажиллагааг тогтмолжуулж ажлын байрыг бий болгож, халуун ус, үсчин, оёдол, гуталчин зэрэг нэн шаардлагатай үйлчилгээг нэмэгдүүлж, уг үйлчилгээг малчдад хүргэх бодлого баримтлаж ажиллана.

2.6. Төсөв санхүүгийн чиглэлээр

- 2.6.1. Эдийн засгийн хэмнэлттэй, ашигтай төсөв санхүүгийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.6.2.Төрийн байгууллагуудын байнгын хэрэгцээт бараа үйлчилгээний зах зээлийн эргэлт нийлүүлэлтийн Цахим худалдааг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 2.6.3.Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлтийг нэмэгдүүлж татварын орлогыг жил бүр 100 хувь төвлөрүүлнэ.
- 2.6.4.Орон нутгийн өмч ашиглалт, хамгаалалтыг сайжруулна.
- 2.6.5. Төрийн болон орон нутгийн өмчийг бүртгэлжүүлж өмчийн үр ашгийг дээшлүүлнэ.
- 2.6.6.Төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг танах, хэмнэлтийн горимд шилжүүлэх бодлого баримтална.
- 2.6.7. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулж мэдээллийг ил тод болгоно.
- 2.6.8.Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтыг үр дүнтэй, иргэдэд нээлттэй ил тод болгох, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, ашиглалтад тавих хяналтыг сайжруулна.



ГУРАВ. ДЭД БҮТЦИЙН БОДЛОГО

Бид хамтдаа сумынхаа үйлдвэрлэл, дэд бүтцийн хөгжлийг түүчээлнэ.

3.1. Ундны усны найдвартай эх үүсвэрийн чиглэлээр

3.1.1. “Сумын төвийн усан хангамжийг сайжруулан, хүн амын ундны усны эрүүл ахуйн стандартыг бүрэн хангуулж ухаалаг худгийг нэмэгдүүлэх.

3.1.2. Сумын төвийн ундны усны худагт шүүлтүүрийн ашиглалтыг сайжруулж түүхий эдээр хангана.

3.1.3. Булгийн эхийг хамгаалах, усны урсац голын дагуух бүрэн хамгаалж ажиллах.

3.2. Эрчим хүчний өргөтгөл, нэгдсэн халаалт шинэчлэлийн чиглэлээр

3.2.1. Сумын төвийн цахилгаан хангамж 0.4 кв-ын шугамыг өртгөтгөж трансформатр болон дамжуулах дэд станцын найдвартай ажиллагааг хангаж, шинэ суурьшлын бүсэд цахилгааны шугам сүлжээг оруулна.

3.2.2. Сумын төвийг орчин үеийн дэвшилтэт технологи бүхий халаалт, цэвэр бохир усны нэгдсэн системтэй болгох ажлыг судлаж шийдвэрлүүлнэ.

3.3. Зам, тээвэр, үйлвэржилтийн бүтээн байгуулалтын чиглэлээр

3.3.1. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан сумын төвд авто замын гэрэлтүүлэг, замын тэмдэг тэмдэглэгээг хийж хаягжуулна.

3.3.2. Орчин үеийн технологиор хүнсний ногоо, жимс жимсгэнийг савлаж, сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах бичил үйлдвэр байгуулан, орон нутгийн хэрэгцээг бүрэн хангах арга хэмжээг бодлогоор дэмжинэ.


3.3.3. Аялал жуулчлалыг дагасан үйлдвэрлэл, үйлчилгээг бүх чиглэлээр хөгжүүлэх арга хэмжээ авна.

3.3.4. “Нэг сум-нэг үйлдвэр” хөдөлгөөний хүрээнд, иргэдийн орлого ашгийг нэмэгдүүлнэ.

3.3.5. Орон нутгийн чанартай зам давааг засварлах, сэргээн шинэчлэх ажлыг нийтийг хамарсан ажил үйлчилгээ, бусад төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх зохион байгуулалтын арга хэмжээг дэмжинэ.

3.4. Хот байгуулалт, барилга орон сууцны хөгжлийн чиглэлээр

3.4.1. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж батлуулж “Сумын ирээдүй” хөтөлбөр боловсруулан жишиг сум болгох хөрөнгө оруулалтыг үе шаттай хэрэгжүүлнэ.



3.4.2. Сумын төвийн дэд бүтцийг сайжруулан цэвэр бохир ус, халаалт, дулааны нэгдсэн шугам сүлжээнд холбох ажлыг эхлүүлж, нийтийн орон сууцнуудын өнгө зүсийг сайжруулах замаар төсөл хөтөлбөрт хамруулна. .

3.4.3. Энгийн хялбар технологиор зам талбай, засал чимэглэл, тохижилтын жижиг бүтээц, тоосго блок зэрэг барилгын дүүргэгч материалын үйлдвэрлэл эрхлэх хувийн хэвшилтэй хамтран ажиллана

3.4.4. Сумын төвлөрсөн хогийн цэгийг дарах шилдэг технологийг судалж, хог хаягдлыг ангилж, цэгцлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.

3.4.5. Жишиг сум болох зорилтийн хүрээнд **жишиг гудамж** аяныг эхлүүлнэ.

3.4.6. Ногоон байгууламжийг өргөжүүлж ногоон сум болох хөдөлгөөн өрнүүлнэ.

3.4.7. Сумын 100 жилийн ойн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

3.4.8. Сумын иргэдийн аюулгүй байдлын үүднээс үерийн усанд идэгдээд байгаа Тэгшийн ганганы нуралтыг зогсоож, аюулгүй зорчих, амьдрах ажлыг бий болгоно.

3.4.9. Рашаант багийн төвийг шинээр барих, бусад багийн төвүүдэд иж бүрэн засвар хийнэ.

3.5. Мэдээлэл харилцаа холбооны дэвшлийн чиглэлээр

3.5.1. Сумын холбооны шилэн кабелийг ашиглалтыг сайжруулж , харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, интернэтийн 4G цахим үйлчилгээг ард иргэдэд хүргэн сүлжээгүй газруудыг сүлжээний өргөтгөл хийлгэнэ.

3.5.2. Багуудын үүрэн холбооны сүлжээг сайжруулах ажлыг үүрэн холбооны компаниудтай хамтран шийдвэрлэж “ Интернэт малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.


ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН – АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО

Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчны бохирдол, доройтлыг хязгаарлан зогсоож, хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлж, орон нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

4.1. Онгон байгалиа хамгаалах чиглэлээр

4.1.1. Ээж хайрхан уулын цогцолборт газарт гадаад дотоодын аялал жуулчлалыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажиллана.

4.1.2. Сумын төвийн ногоон байгууламжийн усалгаа, арчилгааг бүрэн шийдвэрлэж, хайс хамгаалалтыг сайжруулна.



4.1.3. Байгууллага, аж ахуйн нэгж бүрийг хуулийн дагуу ойжуулах, цэцэрлэгжүүлэх ажилд дайчлан оролцуулах замаар “НОГООН БАЙГУУЛАМЖ”, “НОГООН БАЙГУУЛЛАГА”, “ХАШААНДАА САЙХАН АМЬДАРЪЯ” “ЭРҮҮЛ ОРЧИН ЭРҮҮЛ ЦОГТ” “хөдөлгөөн өрнүүлнэ.

4.1.4. Мод тарьсан иргэдийг урамшуулах журам гарган хэрэгжүүлж, мод үржүүлэн орлого олох боломжийг бүрдүүлнэ.

4.1.5. Орон нутгийн чанартай уул овооны тайлга тахилгыг холбогдох ном журмын дагуу гүйцэтгэж, уул усаа тахиж хайрлан хамгаалах үзлийг нийтэд төлөвшүүлэх ажлыг зохион байгуулна.

4.1.6. Голын ай сав, цөлжилт, элсний нүүдэл бүхий газруудыг ойжуулах иргэд, аж ахуйн нэгжийн санал санаачилгыг дэмжиж ажиллана.

4.1.7. Орон нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

4.1.8. Байгалын үзэсгэлэнт газруудын богино хэмжээний баримтат кино, шторкуудыг мэргэжлийн өндөр түвшинд хийлгэн сурталчилж, гадаад, дотоодын аялал жуулчлалыг шинэ шатанд гарган орон нутгийн жуулчдын тоог нэмэгдүүлэх замаар орлого үр ашгийг нэмэгдүүлнэ.

4.1.9. Аялал жуулчлал эрхлэх аж ахуйн нэгж, иргэдийн цогцолбор, бааз байгуулах төслүүдийг хэрэгжүүлэхэд хамтарч, ажиллана.

4.1.10. Явган болон дугуйн аялалын богино маршруттай болох ажлыг дэмжиж ажиллана .

4.1.11. Аялал зугаалга, уул овооны тахилга зохион байгуулсан газар нутгийн хог хаягдлыг цэвэрлэн ариутгаж тухайн засаг захиргааны нэгжид хүлээлгэн өгдөг журмыг хэвшүүлнэ.


4.1.12. Орон нутгийн бахархалт гайхамшигт газар, ан амьтан, уул усны дүрстэй бэлэг дурсгалын зүйл үйлдвэрлэж борлуулах эрхийг сонгон шалгаруулалтаар олгох ажлыг эхлүүлнэ.

4.1.13. Аялал жуулчлалд суурилсан өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, түүнээс орлого олж ажиллах малчид иргэд нөхөрлөл хоршоодыг дэмжинэ.

4.1.14. Орон нутгийн оюутан залуусыг зуны амралтаараа аялал жуулчлалын чиглэлээр ажиллаж орлогын эх үүсвэртэй болох боломжийг дэмжинэ.

4.2 Бичил уурхай иргэдийн оролцооны чиглэлээр

4.2.1. Хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн тайланг гаргуулан, дүгнэлт хийж, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжиж ажиллана.



4.3 Орон нутгийн тусгай хамгаалалтыг нэмэгдүүлэх чиглэлээр

4.3.1 Сумын тусгай хамгаалалттай газар нутгийг шинэчлэн баталгаажуулах, ховор амьтан ургамал, түүх соёлын газрын хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авна.

4.3.2 Орон нутаг дахь уул уурхайн үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд явуулах хяналтыг сайжруулж, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

4.3.3 Байгаль орчны хуулийн дагуу иргэн бүр мэдээлэгч-хамгаалагч байх тогтолцоог бүрдүүлэн, урамшууллын систем тогтоож хэрэгжүүлнэ.

4.3.4 Ан амьтдын тооллогыг орчин үеийн багаж, тоног төхөөрөмж, арга хэрэгсэл ашиглан хийж, нөөцийн судалгааг шинэчлэн, байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөл боломжийг дээшлүүлнэ.

4.3.5 Усны нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, булаг, шанд, уст цэгийн тоог нэмэгдүүлэх, хамгаалах ажлыг тогтмол зохион байгуулна.

4.3.6 Байгаль хамгаалах зорилгоор нэгдэх бүлэг нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжиж, тэдэнтэй хамтран ажиллана..

4.4 Цөлжилт, элсний нүүдлээс хамгаалах, ногоон байгууламжийн чиглэлээр

4.4.1 Байгальд ээлтэй амьдрах ухааны хичээл, сургалтыг боловсролын байгууллагатай хамтран хийж, өсвөрийн Байгаль хамгаалагчдыг ажиллуулан удаан шингэдэг, задардаггүй хог хаягдал, сав баглаа боодлоос татгалзуулах ажлыг зохион байгуулна.

4.4.2 “Хоггүй цэвэр Сум” хөдөлгөөнийг өрнүүлж, хамтдаа эрүүл цэвэр амьдрах орчныг бүрдүүлнэ.

4.4.3 Булаг шандны эхийг хамгаалан, моджуулж, ургамалжуулах ажлыг малчид, хоршоо, нөхөрлөлтэй хамтран хийж, усны ундаргыг нэмэгдүүлнэ.


4.4.4 Үүлэнд зориуд нөлөөлөх, хур тундасны хэмжээг нэмэгдүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран явуулна.

ТАВ. ИРГЭДИЙН ОРОЛЦОО - ЗӨВ ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Иргэдийнхээ итгэл дэмжлэгийг хүлээсэн төрийн хариуцлагатай тогтолцоог төлөвшүүлнэ.

5.1 Эрх мэдэлтнийг биш, эрх зүйт төрийг дээдлэх чиглэлээр

5.1.1. Төрийн албаны ажлын байранд тавигдах шаардлагыг бүрэн хангаж, нээлттэй шалгаруулалтанд шалгарсан хүнийг төрийн албанд томилдог шударга зарчмыг бүрэн хэрэгжүүлнэ.



5.1.3. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, багийн Иргэдийн нийтийн хуралд зөвшилцлийн зарчмыг тууштай баримталж, цөөнхийг хүндэтгэж, оновчтой санал, санаачилгыг нь дэмжиж ажиллана.

5.1.4. Төрийн албан хаагчдыг давтан сургалтад хамруулж чадавхжуулна.

5.1.5. Төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж, жил бүр нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинэжилгээнд хамруулна.

5.2. Түмэндээ ойртсон төрийн үйлчилгээг хүргэх чиглэлээр

5.2.1. Тулгамдсан, нэн шаардлагатай зорилтуудыг олж тодорхойлох, тэдгээрийг шийдвэрт тусгаж хэрэгжүүлэх, шаардлагатай асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулдаг болно.

5.2.2. Төрийн ажил үйлчилгээг иргэдэд нээлттэй хөнгөн шуурхай, чирэгдэл, хүндрэлгүй хүргэх бүх нөхцөл шаардлагыг сумын түвшинд жигд хэрэгжүүлж төрийн үйлчилгээг минутжуулсан ажлыг хэрэгжүүлнэ.

5.2.3. Төрийн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд 51 төрийн үйлчилгээний 103 лавлагаа мэдээллийг олно.

5.2.4. Багуудын ажиллах нөхцлийг сайжруулж, багийн дарга, эмч нарыг багийн төв дээр тогтмол ажиллуулах боломжийг бүрдүүлнэ.


5.2.5. Иргэдээ сонсох нээлттэй утсыг байнга ажиллуулж, санал гомдлын мөрөөр бодит ажил зохиож үр дүнг мэдэгдэж хэвшинэ.

5.2.6 Иргэний танхимийн үйл ажиллагааг тогтмолжуулж, орон нутагт тулгамдаж буй асуудлаар нээлттэй хэлэлцүүлгийг тогтмол явуулж иргэдээс гарсан санал санаачлагыг орон нутгийн бодлого шийдвэрт тусгаж ажиллана.

5.2.7. Улаанбаатар хот болон бусад аймаг хотуудад байгаа Цогт сумын нутгийн зөвлөлүүд, иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагуудтай харилцан хамтран ажиллаж, тэдгээрийн сум орон нутгаа хөгжүүлэх аливаа үйл ажиллагааг онцгойлон анхаарч дэмжиж ажиллана.

5.2.8. Монгол бичгийг төрийн албан хэрэгт хөтлөх ажлыг үе шаттай хийж сургалт зохион байгуулна.

5.3 Авилга, хүнд суртал, чирэгдэлгүй зөв засаглалын чиглэлээр



5.3.1 Төрийн байгууллагуудын хүнд сурталгүй, зарчимч, шуурхай, ил тод, нээлттэй байдлыг хангана. Үүний тулд шилэн данс, төрийн албаны бусад цахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, хүрээг өргөтгөнө.

5.3.2 Төрийн нууцад хамаарахаас бусад мэдээлэлтэй иргэд тогтмол танилцаж байх боломжоор хангана.

5.3.3 Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд саад учруулж байгаа элдэв зөвшөөрөл, хязгаарлалтыг багасгаж, нийтийн эрх ашгийг хамгаалсан, зайлшгүй байх заавар, журмуудыг боловсруулж хэрэгжүүлнэ.

5.3.4 Төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлдэг болно.

5.3.4 Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагуудын хүнд суртлыг арилган, иргэдэд чирэгдэлгүй хөнгөн шуурхай үйлчилгээ хүргэнэ.

5.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах хууль сурталчилах ажлын чиглэлээр

5.4.1 Архидан согтуурах явдал, ахуйн болон малын хулгайтай тууштай тэмцэж, малын хулгайгүй сум болох нөхцлийг бүрдүүлэн мал хамгаалах санг бий болгоно.

5.4.2. Төрийн байгууллагын албан хаагчдын ёс зүйг сахиулж, хүний эрх, эрх чөлөөг хангана.


5.4.3. Төв суурин газрыг камержуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орчныг бүрдүүлнэ.

5.4.4 Гэмт хэргийн гаралтыг бууруулах талаар иргэдийн идэвх оролцоог дэмжиж ажиллана.

5.4.5. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, багийн нөхөрлөл, бүлгийн үйл ажиллагааг идэвхижүүлнэ.

5.4.6. Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар нь Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилт, шинэчилэлт, өөрчлөлтийн талаар Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран улирал бүр сургалт сурталчилгааны ажлыг явуулах.

oo OO oo



8217144139
Д:ОА000000018301